



## ЭХ ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР ДЭХ ЗӨВ БИЧИХ ДҮРМИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Намсрайн Даваасүрэн  
МУБИС-Багшийн сургууль, ахлах багш, доктор

Холбоо барих зохиогч: [davaasuren.n@msue.edu.mn](mailto:davaasuren.n@msue.edu.mn) 

Хүлээн авсан: 2023.11.11

Хянагдсан: 2023.12.12

Зөвшөөрсөн: 2023.12.25

### Хураангуй

Монгол кирилл бичгийг бүх хэвлэл, улсын хэргийг хөтлөхөд хэрэглэх шийдвэр гарсан үеэс эхлэн, ЕБС-д шинэ үсгийн дүрмийг зааж, энэ бичгээр зөв бичиж сургах нь монгол хэлний сургалтын агуулгын үндсэн хэсэг болсон байна. Гэсэн хэдий ч өнөөдөр суралцагчдын зөв бичих чадвар төдийлөн хангалттай бус байгааг судлаачид болоод арга зүйчид шүүмжилсээр байна. Үүнд нөлөөлөх нэг хүчин зүйл нь эх хэлний сургалт дахь зөв бичих дүрмийн агуулга байх магадлалтай хэмээн үзэж, чухам ямар дүрмийг аль ангид, ямар агуулгын хүрээнд судалж буйг тодруулах үүднээс эх хэлний сургалтын зарим хөтөлбөрт харьцуулсан судалгаа хийсэн болно. Судалгаанаас бага ангийн монгол хэлний хичээлийн агуулгад зөв бичих дүрэм чухал байр суурь эзэлсээр ирсэн бөгөөд бүх нийтийн зөв бичих чадварт сургахад бичиг үсэгт тайлагдах мөчөөс анхаарч, зөв бичих дүрмийн суурь чадвар бага ангид тавигддаг нь тодорхой.

Зөв бичих дүрмийг бага ангид судалсан хэвээр байгаа боловч 2000 оноос хойш бусад ангид тусгайлан судлахгүй байгаагаас хэлний мэдлэг гүн бат байх зарчим алдагдахад хүрчээ. Түүнчлэн зарим дүрмийг бага, дунд, ахлах ангийн алинд ч заахгүй байгаа нь суралцагчдын зөв бичих чадварт сөрөг нөлөө үзүүлж байна.

### Түлхүүр үг

Монгол хэлний сургалт, суралцагчдын зөв бичих чадвар, нөлөөлөх хүчин зүйл

### Удиртгал

Монгол Улс тухайн цаг үеийн шаардлагаар орос хэлний цагаан толгойд үндэслэн, шинэ үсэг зохион хэрэглэсэн билээ. Тодруулбал, 1941 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн МАХН-ын Төв хорооны тэргүүлэгчид ба Сайд нарын Зөвлөлийн хамтарсан хурлаас монгол бичгийг шинэ орос үсэгт шилжүүлэх нь зүйтэй гэж үзэн, “Монголын шинэ үсгийг тогтоох тухай” тогтоол (22/17) баталжээ. Шинэ үсэг зохиох төлөвлөгөөг Ю.Цэдэнбалаар ахлуулсан улсын комисст даалгаж, мөн оны 5 дугаар сарын 9-нд

“Орос үсэгт үндэслэсэн монголын шинэ үсгийг батлах тухай” тогтоол (25/27) гарч, кирилл монгол үсгийг бичих ба хэрэглэх түр дүрмийг боловсруулан гаргах, цагаан толгой, сурах бичиг бэлтгэхийг ШУХ, Ардыг гэгээрүүлэх яаманд даалгажээ. 1941-1946 онд улсын албан хэргийг шинэ үсгээр явуулах бэлтгэл хийж, 1945 оны 5-р сарын 18-нд МАХН-ын Төв хороо, Сайд нарын зөвлөлийн “Бүх хэвлэл ба улсын албан хэргийг шинэ үсгээр явуулах тухай” тогтоол (31/27) батлагдан, 1946 оны 01 сарын 1-ний өдрөөс төрийн албан ёсны хэлэнд уг бичгийг хэрэглэж эхэлжээ.

Кирилл үсэгт тулгуурласан шинэ үсгийн ач холбогдлыг “Шинэ үсгийн комисс”-ын тогтоолд “Манай шинэ үсгийн зөв бичих дүрэм нь монголчуудын халхын төв аялгуун дээр дуун ухааны судлал ба үг бүтэх ёсыг баримтлан, ардын ярианы хэлд ойр зохиогдож чадсан” гэж үнэлжээ. Улмаар 1960-аад оны эцсээр бүх нийтийн 90 гаруй хувь нь бичиг үсэгтэн болсон бөгөөд энэхүү амжилтыг ЮНЕСКО өндрөөр үнэлж, “Бүх нийтээр бичиг үсэгтэн болсны шагнал”-ыг БНМАУ-д хүртээсэн билээ. (Төмөртоогоо, хууд. 326)

Монголын ард түмнийг бүх нийтээр бичиг үсэгтэн болоход онцгой гавьяа байгуулсан монгол кирилл бичгийг бүх хэвлэл, улсын хэргийг хөтлөхөд хэрэглэх шийдвэр гарсан үеэс эхлэн, ЕБС-д шинэ үсгийн дүрмийг зааж, энэ бичгээр зөв бичиж сургах нь монгол хэлний сургалтын агуулгын үндсэн хэсэг болсон байна. Гэсэн хэдий ч суралцагчдын зөв бичих чадвар төдийлөн хангалттай бус байгааг судлаачид болоод арга зүйчид шүүмжилсээр байна. Үүнд нөлөөлөх нэг хүчин зүйл нь эх хэлний сургалт дахь зөв бичих дүрмийн агуулга байх магадлалтай хэмээн үзэж, чухам ямар дүрмийг аль ангид, ямар агуулгын хүрээнд судалж буйг тодруулах үүднээс эх хэлний сургалтын зарим хөтөлбөрт харьцуулсан судалгаа хийсэн болно.

## **Судалгааны арга зүй**

Уг судалгаанд эх хэлний сургалтад мөрдөж ирсэн болон мөрдөж буй хөтөлбөрүүд, тухайлбал, “Бага ангийн монгол хэл бичгийн программ” (1984), “ЕБС-ийн монгол хэлний хичээлийн стандарт” (1998), “Монгол хэл, уран зохиолын боловсролын стандарт” (2004-2008), “Монгол хэлний сургалтын цөм хөтөлбөр” (2014), “Монгол хэлний сургалтын хөтөлбөр” (2019) дэх зөв бичих дүрмийн агуулгад харьцуулсан судалгаа хийсэн болно.

## **Сургалтын хөтөлбөр дэх зөв бичих дүрмийн агуулгад хийсэн ажиглалт**

1946 оноос монгол хэлний сургалтад мөрдөж байсан болон мөрдөж буй хөтөлбөр, программаас харахад бага ангид нь зөв бичүүлж сургахад голлон анхаарч ирсний зэрэгцээ дунд ангийн эхний ангид, тухайлбал, 1972-1992 онд 4 дүгээр ангид, 1992-2004 онд 5 дугаар ангид авиа зүй, зөв бичих зүйг тусгайлан зааж байжээ. Харин 1976 он хүртэл ерөнхий боловсролын сургуулийн дунд ангиудад авиа зүй, зөв бичих дүрмийг 100 гаруй цаг зааж байсанд дүгнэлт хийж, цаашид цагийг багасгах арга хэмжээ авсан байна. 1985 оноос мөрдсөн дунд ангийн хөтөлбөрөөс үзэхэд IY, Y, YI ангид авиа зүй, үсгийн дүрэм, зөв дуудах зүй, үгийн сан, үг зүйг голлон зааж байсны дотор IY ангид судлах монгол хэлний хичээлийн 175 цагийн 63 хувьд авиа зүй, зөв бичих дүрмийг зааж байв. 1996 оны хөтөлбөрт Y ангид судлах 90

цагийн гуравны нэгд нь авиа зүй, үсэг зүй, зөв бичих зүйн асуудал эзэлж байжээ. (Бямбацэрэн, 2015)

Доктор (Sc.D), профессор Ц.Оюун 1937-2000 онд ЕБС-ийн дунд, ахлах ангид зөв бичих дүрмийг дараах агуулгаар судалж байсныг бүртгэжээ. Түүний дүгнэснээр зөв бичих дүрмийг авиа зүйн бүлэгт хамруулан судлахдаа 1937-1940, 1961-1980, 1996 оноос хойших хугацаанд 5-р ангид, 1941-1960 онд 6-р ангид, 1961-1995 онд 4-р ангид голчлон зааж байсан нь тодорхой байна. Зөв бичих зүйг 1937-1990-ээд оныг хүртэл дунд, ахлах ангийн монгол хэлний сургалтын тулгуур болгож байсан ба ингэхдээ 1930-1940-өөд онд хэрэглээний дадлага, чадварт их анхаарч байснаа 1945-1990-ээд оны үед зөв бичих зүйн дүрмийг голлон, нэлээд онолын хандлагатай болсон байна. Тухайлбал, 1949 оны үед мөрдөж байсан YI ангийн монгол хэлний хөтөлбөрт нийт 110 сэдэв байгаагийн 84 буюу 66.4 хувь нь зөв бичгийн дүрэмтэй холбоотой байна. (Оюун, хууд. 46)

“Монгол хэл, уран зохиолын боловсролын стандарт” (2004-2008)-ын суурь боловсролын агуулгын стандартын ”Бүтээврийн найруулга” мэдлэгийн хүрээнд “Зөв бичгийн дүрмийн болон найруулгын алдаагүй бичих, зөв бичгийн дүрмийн болон найруулгын алдааг олох, засах, учрыг тайлбарлах чадварт суралцах (2004, х.37), бүрэн дунд боловсролын агуулгын стандартад “...эх зохиож бичихдээ зөв бичих дүрмийн алдаагүй бичих чадварт суралцах” гэж томъёолжээ.

Мөн 2014 оноос хойш мөрдөж байгаа “Монгол хэлний сургалтын хөтөлбөр”-т суурь боловсролын YI, YII ангид “бүтээврийн нийлцийг зөв бичих дүрмээр бичих”, IX ангид “цэг, цэглэлийн дүрмийг хэрэглэх” гэж оруулсан байна.

Бага ангийн монгол хэлний сургалтын хөтөлбөрт зөв бичих дүрэм хэрхэн туссаныг “Бага ангийн монгол хэл бичгийн программ” (1984), “ЕБС-ийн монгол хэлний хичээлийн стандарт” (1998) “Монгол хэл, уран зохиолын боловсролын стандарт” (2004), “Бага боловсролын монгол хэлний сургалтын хөтөлбөр” (2019)-өөр жишээлэн үзүүлье.

Хүснэгт 1. Сургалтын хөтөлбөр дэх «Зөв бичих дүрэм» агуулгын харьцуулсан судалгаа (1984,1998)

<b>Хөтөлбөрийн нэр</b>		
<b>Анги</b>	<b>Бага ангийн хэл бичгийн хичээлийн программ (1984)</b>	<b>ЕБС-ийн монгол хэлний хичээлийн стандарт (1998)</b>
I	<ul style="list-style-type: none"> <li>• Эгшиг, гийгүүлэгч авианы ялгаа</li> <li>• Эр, эм, саармаг эгшгийн ялгаа</li> <li>• Хатуу, зөөлөрсөн гийгүүлэгч</li> <li>• Зарим гийгүүлэгч (“н”, “г”) –ийн ялгаа</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Эр, эм, саармаг эгшиг, богино, урт, хос эгшиг, өргөлтөт ба балархай эгшиг</li> <li>• Ялгах эгшиг</li> <li>• Эгшиг зохицох ёс</li> </ul>

II	<ul style="list-style-type: none"> <li>• Авиа үсэг, зөв бичих</li> <li>• Өргөлттэй ба балархай эгшиг</li> <li>• Эгшигт, заримдаг гийгүүлэгчийг зөв бичих</li> <li>• ж, ч, ш заримдаг гийгүүлэгчийн дараа үгийн дунд балархай эгшиг зөв бичих</li> <li>• Ялгах эгшиг</li> <li>• Зөөлөрсөн гийгүүлэгчийг бичигт тэмдэглэх</li> <li>• Зөөлний тэмдэг “и”-гээр солигдох, үл солигдох тухай</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• я-ийн төрлийн урт, хос эгшгийг бичих</li> <li>• Зөөлөрсөн гийгүүлэгчийг зөв бичих</li> <li>• Балархай эгшиг гээгдэх ба гээхгүй бичих</li> <li>• Үгийн дунд орсон ж, ч, ш-ийн дараа богино эгшиг бичих</li> <li>• Зөөлөрсөн гийгүүлэгчийн дараах урт эгшгийг бичих</li> </ul>
III	<ul style="list-style-type: none"> <li>• Авиа үсэг, зөв бичих</li> <li>• Үе шилжүүлэх, үеийн бүтэц, битүү ба задгай үе, үе шилжүүлэх дүрэм</li> <li>• Эгшгийн дарааллын дүрэм</li> <li>• Гээгдэх эгшиг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Эгшиг зохицох ёс</li> <li>• Том үсгийн дүрэм</li> <li>• Үг шилжүүлэх дүрэм</li> <li>• Хатуу ба зөөлний тэмдгийг зөв бичих</li> </ul>

Эндээс харвал, бага ангид эгшиг, гийгүүлэгчийн ангиллаас эхлээд “Эгшигт гийгүүлэгчийн дүрэм” (§16), “Заримдаг гийгүүлэгчийн дүрэм” (§17, 18), “Эгшиг зохицох ёс” (§8), “Гээгдэх эгшгийн дүрэм” (§28), “Гээгдэхгүй эгшгийн дүрэм” (§30), “Ялгах эгшгийн дүрэм” (§22, 23, 24), “Зөөлөрсөн гийгүүлэгчийг тэмдэглэх нь” (§31), “Зөөлний тэмдгийн солигдох нь” (§32), “Зөөлний тэмдгийн үл солигдох нь” (§33), “Ж, ч, ш-ийн дараах эгшгийг бичих дүрэм” (§27), “Үгийг үелэх дүрэм” (§45), “Мөр шилжүүлэх дүрэм” (§46), “Том үсгийн дүрэм” (§47) зэрэг гол дүрмийг судалж байжээ.

1998-2004 онд бага ангид мөрдсөн “ЕБС-ийн монгол хэлний хичээлийн стандарт”-аас үзвэл I-III ангид зөв бичих тодорхой дүрмийг хэсэглэн оруулсан бол 2004-2008 онд мөрдөж байсан “Монгол хэл, уран зохиолын боловсролын стандарт”-ын бага боловсролын агуулгын стандартад “Хэлний соёл ай”-н “Авианы найруулга” мэдлэгийн хүрээнд, ихэнх дүрмийг судлахаар оруулжээ. Тухайлбал, I ангид цагаан толгойн 35 үсгийг таних, нэрлэх, дэс дарааллыг мэдэх, эгшиг ба гийгүүлэгч авиаг ялган таних, богино, урт, хос эгшгийг ялгах, бичих, II ангид Эгшигт ба заримдаг гийгүүлэгч, өргөлтөт ба балархай эгшиг, эр, эм, саармаг эгшиг, “-ий, -ы” ялган бичих дүрэм, “н, г” –г бичих дүрэм, III ангид балархай эгшгийн үүрэг (эгшигжүүлэх, ялгах, зөөлрүүлэх), том үсэг, цэг цэглэлийн дүрэм, IV ангид “ж, ч, ш” –ийн дүрэм, эгшиг зохицох ёс, түүнийг зөрчих тохиолдол, V ангид дан ба давхар зөөлөрсөн гийгүүлэгч, зөөлний тэмдэг “и” болох, болохгүй тохиолдол зэрэг дүрмүүдийг судалжээ. Эндээс харвал, кирилл бичгийн суурь дүрмүүдийг судлахаар оруулсан боловч тэдгээр дүрэмтэй нягт уялдаа холбоо бүхий “Гээгдэх ба гээгдэхгүй эгшгийн дүрэм”, “Үйл үг бүтээх “-л” дагаврын дүрэм” зэрэг тодорхой дүрмийг судлаагүй нь харагдаж байна.

2008-2014 онд ЕБС-д мөрдөж байсан “Бага ангийн монгол хэлний сургалтын хөтөлбөр”-т зөв бичих дүрмийг анги ахих тутам гүнзгийрүүлэн заах зарчмыг

баримталжээ. Тухайлбал, II ангид эгшгийн ангилал ба эр, эм үг, эгшигт ба заримдаг гийгүүлэгчийн дүрэм, өргөлтөт ба балархай эгшиг, эгшиг зохицох ёс, ялгах эгшгийн дүрэм, III ангид балархай эгшгийн эгшигжүүлэх, зөөлрүүлэх, ялгах үүрэг, том үсэг, цэг цэглэлийн дүрэм, IV ангид “ж, ч, ш”-ийн дүрэм, эгшиг зохицох ёсыг зөрчих тохиолдол” –ыг судлахаар тусгасан байна. “Монгол хэлний бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр”-т анги дэвших бүр зөв бичих чадвар ахих дарааллаар оруулжээ.

2004 -2008 онд мөрдөж байсан “Монгол хэл, уран зохиолын боловсролын стандарт” болоод 2019 онд шинэчлэн боловсруулсан “Бага боловсролын монгол хэлний сургалтын хөтөлбөр” дэх зөв бичих дүрмийн агуулгыг харьцуулан авч үзье. Үүнд:

## Хүснэгт 2. Сургалтын хөтөлбөр дэх «Зөв бичих дүрэм» агуулгын харьцуулсан судалгаа (2004, 2019)

Хөтөлбөрийн нэр	
Анги	Монгол хэл, уран зохиолын боловсролын стандарт (2004)
	Бага боловсролын монгол хэлний сургалтын хөтөлбөр (2019)
I	<ul style="list-style-type: none"> <li>Цагаан толгойн 35 үсгийг таних, нэрлэх, дэс дарааллыг мэдэх</li> <li>Эгшиг ба гийгүүлэгч авиаг ялган таних</li> <li>Богино, урт, хос эгшигийг ялгах, бичих</li> </ul>
II	<ul style="list-style-type: none"> <li>Эгшигт ба заримдаг гийгүүлэгч</li> <li>Өргөлтөг ба балархай эгшиг</li> <li>Эр, эм, саармаг эгшиг</li> <li>“-ий,- ы”-г ялган бичих дүрэм</li> <li>“н, г” –г бичих дүрэм</li> </ul>
III	<ul style="list-style-type: none"> <li>Балархай эгшигийн үүрэг (эгшигжүүлэх, ялгах, зөөлрүүлэх)</li> <li>Том үсэг, цэг, цэглэлийн дүрэм</li> </ul>
IV	<ul style="list-style-type: none"> <li>“ж, ч, ш” –ийн дүрэм</li> <li>Эгшиг зохицох ёс, түүнийг зөрчих тохиолдол</li> </ul>
V	<ul style="list-style-type: none"> <li>Дан ба давхар зөөлөрсөн гийгүүлэгч</li> <li>Зөөлний тэмдэг “и” болох, болохгүй тохиолдол</li> </ul>

Дээрх судалгаанаас “Монгол хэл, уран зохиолын боловсролын стандарт” (2004) дахь зөв бичих дүрмийг “Бага боловсролын монгол хэлний сургалтын хөтөлбөр” (2019)-т анги ахих бүр агуулга өргөсөх, гүнзгийрэх дарааллаар оруулсан нь тодорхой байна. Тухайлбал, “Том үсгийн дүрэм”-ийг 2004 оны хөтөлбөрт туссанаар III ангид судлах бол 2019 оны сургалтын хөтөлбөрт I-Ү ангид тэгш хуваарилан оруулсан байна. Мөн “н, г”-г бичих дүрэм”-ийг 2004 оны хөтөлбөрт II ангид судлахаар оруулсан бол 2019 оны сургалтын хөтөлбөрт ”Утга ялгасан үгийг (н, г) зөв дуудах, нүдлэх, зөв бичих”, III ангид ”Утга ялгасан үгийг (н, г) зөв дуудах, нүдлэх, зөв бичих” гэх зэргээр гүнзгийрчээ.

## Судалгааны үр дүн

Судалгаанаас аль ч үеийн бага ангийн монгол хэлний хичээлийн агуулгад зөв бичих дүрэм чухал байр суурь эзэлсээр байгаа нь тодорхой байна. Энэ нь бүх нийтийн зөв бичих чадварт бичиг үсэгт тайлагдах мөчөөс анхаарч, зөв бичих дүрмийн суурь чадвар бага ангид тавигдаж, ийнхүү бага ангидаа эзэмшсэн зөв бичих дүрмийн мэдлэг, чадвар нь насан туршийн зөв бичих чадварын суурь болдгийн нотолгоо юм. Аль ч үеийн бага ангийн сургалтын хөтөлбөрт “Балархай эгшиг” (§15), “Эгшигт гийгүүлэгчийн дүрэм” (§16), “Заримдаг гийгүүлэгчийн дүрэм” (§17, 18), “Тээгдэх эгшгийн дүрэм” (§28), “Гээгдэхгүй эгшгийн дүрэм” (§30), “Г” үсгээр хоёр авиа тэмдэглэх нь” (§22), “Н” үсгээр хоёр авиа тэмдэглэх нь” (§23), “н, г үсгийг ялган тэмдэглэх нь” (§24), “ж, ч, ш-ийн дараах эгшгийг бичих дүрэм” (§27), “Зөөлний тэмдгийн солигдох нь” (§32), “Зөөлний тэмдгийн үл солигдох нь” (§33) зэрэг дүрмийг нэгэн адил тусган оруулжээ.

2014 оноос хойш мөрдөж, 2019 онд сайжруулан боловсруулсан “Суурь боловсролын сургалтын хөтөлбөр”-т сурагчдын эзэмших эх хэлний чадварын нэг болох “бичих чадвар”-ын хүрээнд “Үгийн бүтцийг задлан ялгаж, бүтээврийн нийлцийг зөв бичих” (ҮI, ҮII), “Цэг цэглэлийг хэрэглэх” (IX) зэрэг чадварыг оруулсан бол “Бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр”-т ямар нэг зөв бичих дүрэм судлахаар оруулаагүй байна. Өөрөөр хэлбэл, зөв бичих дүрмийг бага ангид судалсан хэвээр байгаа боловч дунд, ахлах ангид тусгайлан судалдаггүйгээс хэлний мэдлэг гүн бат байх зарчим алдагдахад хүрчээ.

Үүнээс гадна “Зэрэгцүүлэн холбох “-ж, -ч” нөхцөлийг бичих дүрэм” (§40), “Хамааруулах “-х” дагаврыг бичих дүрэм” (§43), “-лага2, -лга2” дагаврыг бичих дүрэм” (§42), “Гадаад үгийг бичих дүрэм” (§49) зэрэг дүрмийг бага, дунд, ахлах ангийн сургалтын хөтөлбөрийн аль алинд тусгаагүй байгаа нь эдгээр дүрмээр алдаатай бичихэд нөлөөлж байгааг анхаарууштай.

## Дүгнэлт

Судалгаанаас дараах дүгнэлтэд хүрлээ.

1. Бага ангид судалсан зөв бичих дүрмийн агуулгыг дунд ба ахлах ангид бататгадаггүй буюу дунд, ахлах ангийн сургалтын хөтөлбөрт тусгаагүйгээс эх хэлний сургалтын залгамжит чанар алдагдахад хүрч, энэ нь суралцагчдын зөв бичих чадвар хангалтгүй байгаад нөлөөлөх нэг хүчин зүйл болж байна.

2. Бүх нийтийн бага ангидаа эзэмшсэн зөв бичих дүрмийн мэдлэг, чадвар нь насан туршийн зөв бичих чадварын суурь болох тул “Багш, бага ангийн боловсрол” хөтөлбөрөөр элсэгчид болоод уг мэргэжлээр суралцагчдын зөв бичих чадварт онцгойлон анхаарах хэрэгтэй.
3. “Зэрэгцүүлэн холбох “-ж, -ч” нөхцөлийг бичих дүрэм” (§40), “Хамааруулах “-х” дагаврыг бичих дүрэм” зэрэг дүрмийг аль ч ангийн сургалтын хөтөлбөрт тусгаагүйгээс “хүсч, нисч, хасчээ, дуусчээ, дараахь, доторхи” гэх мэтээр буруу бичсээр байгаа тул эдгээр дүрмийг эх хэлний сургалтын хөтөлбөрт тусган оруулах шаардлагатай.
4. 1998 оныг хүртэлх хугацаанд бага, дунд ангид зөв бичих дүрмийг авиа зүйн ойлголттой холбон үзэж байсан нь суралцагчдын зөв бичих дүрмийн мэдлэг, чадварт зохих хувь нэмэр оруулж байсныг сэргээн, сургалтын агуулгад тусгах нь зүйтэй.

### **Ном зүй**

- БМДИ, СХУХ. (1984). Бага ангийн хэл бичгийн хичээлийн программ. Улаанбаатар
- БМДИ, СХУХ. (1998) ЕБС-ийн монгол хэлний хичээлийн стандарт. Улаанбаатар
- БСШУЯ. (2004). Бага, дунд боловсрол, монгол хэл, уран зохиолын боловсрол MNS5420-13:2004, Улаанбаатар, Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төв
- БСШУСЯ. (2019). Бага боловсролын сургалтын хөтөлбөр. Улаанбаатар
- БСШУСЯ. (2019). Суурь боловсролын сургалтын хөтөлбөр. Улаанбаатар
- БСШУСЯ. (2019). Бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр. Улаанбаатар
- БШУЯ. (2014). Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр. Улаанбаатар
- Бямбацэрэн, Г. (2015). Бага боловсролын монгол хэлний сургалтын арга зүйн үндэс. УБ
- Оюун, Ц. (2000). Монгол хэлний дидактик (дунд, ахлах анги). Улаанбаатар
- Төмөртоого, Д. “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь”-ийн тухай эргэцүүлэх нь , Хэл зохиол судлал, Улаанбаатар, 2018, х.329
- ХБҮЗ (2018). Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь, Улаанбаатар

## **RESEARCH OF ORTHOGRAPHIC IN THE TRAINING PROGRAM OF MOTHER LANGUAGE**

Davaasuren.N

Ph.D., Lecturer, Teachers school, MNUE

Corresponding author: [davaasuren.n@msue.edu.mn](mailto:davaasuren.n@msue.edu.mn) 

### **Abstract**

Since making the decision to use the Mongolian Cyrillic script for all publications and state affairs, teaching the new alphabet in general secondary schools and learning to write correctly in this script has become the main part of the training programs of Mongolian language.

However, researchers and methodologists have been continuing to criticize that students' writing ability is not sufficient today.

It is considered that one of the influencing factors may be the content of spelling grammar in mother tongue teaching, and in order to clarify which grammar is studied in which class and in which content, a comparative study was conducted in some mother tongue teaching programs.

From seeing the research, it is clear that spelling grammar has been playing an important role in the content of elementary school at Mongolian language lessons, and it is clear that the basic spelling grammar skills are set in the elementary grades, in focusing on the moment of literacy when teaching public spelling skills.

The grammar of correct writing are still studied in elementary school, but from 2000, the principle of deep knowledge of the language has been lost due to the lack of special study in other classes. Therefore, the fact that some rules are not taught in elementary, middle, and high school has a negative effect on students' ability to write correctly.

### **Keywords**

Training of Mongolian language, students' spelling ability, influencing factors

---